



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 8/17

Улаанбаатар хот


Төвийн ажилтнуудыг эрүүл мэндийн
урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 5.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 120.1, Хөдөлмөрийн дотоод журмын 6.2.6 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн “Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах тухай” үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн хамгааллын тусгай төвийн ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсугай.

2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн нийт төлбөрийн 60% буюу 2,653,200 (хоёр сая зургаан зуун тавин гурван мянга хоёр зуун) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас тооцон олгохыг Нягтлан бодогч (Б.Энхдолгор)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ш.МӨНХЦЭЦЭГ

1825010039